



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 30 өдөр

Дугаар А/47

Чойр


Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 7 дугаар зүйлийн 7.3, Ахмад настны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалт, Аймгийн Засаг даргын зөвлөлийн 2024 оны 03 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Сар шинийн баяр”-ыг тохиолдуулан аймгийн хэмжээнд 90 ба түүнээс дээш настай ахмадуудад хүндэтгэл үзүүлэхэд шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2. Хүндэтгэл үзүүлэхэд шаардагдах 2,040,000 (хоёр сая дөчин мянга) төгрөгийг Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Содном)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.БАТСУУРЬ

4214400116

Беловсруулсан: *А. Мунсалхи*  
Хянасан: *А. Багдур*  
Хувь: *2*

Аймгийн Засаг даргын 2024 оны  
 01... дүгээр сарын 30-ны өдрийн  
 А/2... дугаар захирамжийн  
 хавсралт

90 БА ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ АХМАД НАСТНУУДАД ОЛГОХ  
 ГАРЫН БЭЛГИЙН ТӨСӨВ

№	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо/ш	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Календарь	ш	17	4,500	76,500
2	Торго	м	17	60,000	1,020,000
3	Бэлэгний уут	ш	17	3,500	59,500
4	Чацаргана	кг	17	18,000	306,000
5	Сүү	л	17	6,000	102,000
6	Хадаг	ш	17	8,000	136,000
7	Чихэр	кг	17	20,000	340,000
<b>НИЙТ ҮНЭ</b>				<b>120,000</b>	<b>2,040,000</b>

f

p

i

n

— — — — —